



IT OUTSOURCING SERVICE


ҮНДСЭН БИЗНЕСТЭЭ АНХААРАХ
БОЛОМЖ



МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АУТСОРСИНГ ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Мэдээлэл технологийн салбар хурдацтай хөгжихийн зэрэгцээ байгууллагууд IT асуудлаа **шуурхай, найдвартай, цогцоор нь шийдвэрлэх** шаардлагатай тулгарч байна. Мэдээлэл технологийн асуудлаа цогцоор шийдээгүйгээс шалтгаалан бизнесийн үйл ажиллагааг доголдуулах эрсдэлүүд үүссээр байдаг.

Байгууллагын мэдээлэл технологийн дэд бүтцэд тулгарсан асуудлаа мэргэжлийн сертификат бүхий мэргэшсэн инженерийн багаар шийдвэрлүүлэх боломж - **IT OUTSOURCING** үйлчилгээг санал болгож байна. Та мэдээлэл технологийн асуудлаа мэргэшсэн инженерийн багт даатган, үндсэн бизнестээ анхаарах боломжийг бий болгоорой.



ХЭНД

зориулагдсан вэ?
тохиромжтой вэ?



Байгууллагын тань мэдээллийн технологийн асуудлыг хариуцан тогтвортой урт хугацаанд ажиллах, ажлын туршлагатай, мэргэшсэн, олон талын мэдлэгтэй инженер олдохгүй бол;




Байгууллагын тань бүтэц жижиг учраас мэдээллийн технологийн асуудлыг хариуцсан ажилтны орон тоо шаардлагагүй ч, асуудал гарсан тохиолдолд мэргэжлийн өндөр түвшинд шуурхай арга хэмжээ авч, туслалцаа үзүүлэн, шийдвэрлэх мэргэжилтний гардаг бол;



Байгууллагын тань мэдээллийн технологийн дэд бүтэц, орчин, хэвийн ажиллагааг бүрэн ханган ажиллахад ганц инженер хүрэлцээгүй байдаг бол;



Олон улсын байгууллага бөгөөд мэдээллийн технологийн орчин, дэд бүтцийг тогтсон журмын дагуу байгуулах, зааварчилгааны дагуу ажиллагааг хангах шаардлагатай бол;




ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ НАЙДВАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Мэдээллийн технологийн асуудлаас үүдэн бизнесийн үйл ажиллагаа тань доголдох эрсдэлийг бууруулна.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ТӨВЛӨРӨХ

Мэдээлэл технологийн асуудлаа цаг алдалгүй, мэргэшсэн инженерийн тусламжтайгаар шийдвэрлэх боломжтой.




ОНЦГОЙ ЧАДВАРТАЙ МЭРГЭЖИЛТЭН

Олон улсын сертификаттай, тал бүрийн мэдлэг болон туршлагатай, мэргэшсэн инженерийн баг үйлчилгээг үзүүлнэ.




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ХЯНАХ, БУУРУУЛАХ

Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтанд олгох цалин хөлс, даатгал, татвар болон бусад далд зардлуудыг илүү үр өгөөжтэйгөөр зарцуулах боломжтой.



ТИККЕТИЙН СИСТЕМ

Олон улсын стандартад нийцсэн Тиккетийн системийн тусламжтайгаар үйлчилгээний хүсэлтээ хялбар үүсгэх боломжтой ба өөрийн үүсгэсэн хүсэлтийн явцыг хянах болон шаардлагатай үйлчилгээг богино хугацаанд авах боломжтой. Бид 1 цагийн дотор үүсгэсэн хүсэлт болон дуудлагыг хүлээн авч, 4-8 цагийн дотор асуудлыг бүрэн шийдвэрлэдэг.



БҮСЧИЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

Бид үйлчилгээндээ ISO/IEC 20000-1:2018 стандарт болон ITIL v4 тэргүүн туршлагыг мөрдөн ажилладаг. **IT OUTSOURCING** үйлчилгээг Microsoft, Office 365, Azure, Dell, Kaspersky, Trend Micro, Canon зэрэг компаниудын албан ёсны сертификат бүхий мэргэшсэн инженерүүд үзүүлдгээрээ давуу талтай. Байгууллагын тань газарзүйн байршилтай уялдуулан бүсчилсэн үйлчилгээний менежментийн системээр түргэн шуурхай хүрч ажилладаг.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЙЛАН

Бид харилцагчидтайгаа тогтмол уулзалт хийж, дижитал шилжилт хийх явцад хэрхэн ахиц гаргасан талаарх цогц тайланг гаргаж өгдөг. Мэдээллийн технологийн тайланг тогтмолжуулснаар мэдээллийн технологийн стратегийг үнэн, бодит дата мэдээлэлд тулгуурлан сайжруулах болон үүсч болзошгүй эрсдэлийг зөв тооцоолох боломжтой.




МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ

Хөрөнгийн менежмент нь байгууллагын мэдээлэл технологийн хөрөнгийг цаг тухайд нь бүртгэх, байршуулах, арчлах, шинэчлэх, устгахыг баталгаажуулах үйл явц юм. Энгийнээр хэлэхэд, энэ нь танай байгууллагад байгаа биет болон биет бус үнэт зүйлсийг хянаж, ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулах явдал юм. Хөрөнгийн менежмент нь байгууллагын чухал систем, үйлчилгээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийг хянаснаар үүсч болзошгүй эрсдэлийг бууруулдаг.



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ТАЛ

ДИЖИТАЛ АЯЛАЛ



Байгууллагынхаа мэдээллийн технологийн асуудлыг шийдвэрлэхэд тань туслах мэргэшсэн инженерүүд нь мэргэшүүлэх сургалтанд тогтмол хамрагдан, сүүлийн үеийн технологийн шийдлүүдэд тасралтгүй суралцдаг. Ингэснээр харилцагчдадаа орчин үеийн технологийн дэд бүтцийг бий болгоход туслан, Дижитал аяллын тань итгэлт түнш нь байх болно.



Могул Сервис компани нь IT OUTSOURCING үйлчилгээг байгууллагуудад 10+ жил үзүүлж, харилцагчдаа үндсэн бизнестээ анхаарах боломжийг олгодог.



IT OUTSOURCING үйлчилгээг Microsoft, Office 365, Azure, Dell, Kaspersky, Trend Micro, Canon зэрэг компаниудын албан ёсны сертификаттай, мэргэшсэн инженерийн баг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.



ITIL v4 олон улсын мэдээллийн технологийн тэргүүн туршлага болон ISO/IEC 20000-1:2018 стандартыг баримтлан үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг.



Могул Сервис компанийн мэргэшсэн инженерүүд, IT OUTSOURCING үйлчилгээний тусламжтайгаар монгол улсын 50 гаруй байгууллага мэдээллийн технологийн асуудлаа даатган, урт хугацаанд хамтран ажиллаж байна.

Бидэнтэй холбогдох:



<https://www.mogulservice.mn>



<https://www.facebook.com/mogulservice>



<https://www.linkedin.com/company/mogulservice/>



support@mogulservice.mn



+976 7731-2424



Монгол улс, Улаанбаатар хот 17010, Махатма
Гандигийн гудамж, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Хаан Цамхаг оффис, 22 давхар.



/шууд.урьтах.шууд